

№	Банкны нэр	Банк байгуулах зөвшөөрөл олгосон огноо	Холбогдох шийдвэр гаргасан он	Холбогдох тушаал шийдвэрийн дугаар	Шийдвэр	Тайлбар
<b>Монголбанкны шийдвэрээр албадан татан буулгасан болон банкны тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон банкны мэдээлэл</b>						
1	Капитал банк	1991 он	2019 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №А-96	Банкийг албадан татан буулгасан.	Тус банк нь 1991 онд анх Үйлдвэрийн хувь нийлүүлсэн банк нэрээр байгуулагдаж, 1997 онд Шинэчлэл, 2003 онд Капитал банк нэртэй болсон. Банкны тухай хуулийн 16.1.1, 16.1.2 заасан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 0.5 хувь, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт -88.3 хувь болж, заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаагүй болон төлбөрийн чадваргүйд хүрч, хэвийн үйл ажиллагаа алдагдсан тул банкны тусгай зөвшөөрлийг цуцалж, албадан татан буулгах шийдвэр гарснаар тус банканд Эрх хүлээн авагч томилогдсон.
2	Монгол хоршоо банк		1994 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн № 231	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Монгол Хоршоо банкны хүсэлт, Ардын банкны санал, Монголбанкны Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Банкны тухай хуулийн хүрээнд банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тус банкнийг Ардын банктай 1994 оны 09-р сарын 15-ны өдөр нэгтгэсэн байна.
3	Даатгал банк		1996 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №360	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Банк нь 1996 оны 10-р сарын 13-ны өдрийн байдлаар өөрийн хөрөнгө алдагдаж 6.0 тэрбум төгрөг хүрсэн, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааг хангахад 7.7 тэрбум төгрөгийн хөрөнгө нэмэх шаардлагатай, харилцагч хадгаламж эзэмшигчдийн мөнгийг анхны шаардлагаар гаргаж өгч чадахгүй болсон нь тогтоогдсон тул Банкны тухай хуулийн 37-48 дугаар зүйлийг үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг 1996 оны 12-р сарын 13-ны өдрөөр тасалбар болгон хүчингүй болгож, Эрх хүлээн авагч томилсон.
4	Ардын банк		1996 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №359	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Банк нь 1996 оны 10-р сарын байдлаар 30.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлийн 76.3 хувь нь хугацаа хэтэрсэн, өөрийн хөрөнгө нь 17.4 тэрбум төгрөгөөр алдагдаж, пассив нь активаасаа хэтэрсэн, төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон тул банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, Монголбанкнаас томилогдсон Эрх хүлээн авагч ажлын хэсэг тус банкны хадгаламжийг Хадгаламж банканд шилжүүлж, хэвийн бус эзэл, түүнд ногдох эрсдэлийн сан, бусад актив, пассивыг Сэргээн босголт банканд шилжүүлсэн.
5	Их зам банк		1995 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №62	Банк үйл ажиллагааны эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Банкны хуулийн 33 дугаар зүйлийн 2 дугаар заалтад заасан дүрмийн сангийн шаардлагыг хангаагүй, дүрмийн санг зохиомлоор нэмэгдүүлсэн нь тогтоогдсон тул банкны үйл ажиллагааг Банкны хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу 1995 оны 03-р сарын 4-ний өдрөөс эхлэн хүчингүй болгож, Бүрэн эрхт төлөөлөгч томилсон.
6	ХОТШ банк	1992 он	1999 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №646	Банкийг албадан татан буулгасан.	Тус банканд бүтцийн өөрчлөлт хийх боломжгүй гэж үзсэн, мөн Эрх хүлээн авагчийн санал, Банкны тухай хуулийн 31, 38 дугаар зүйлийг үндэслэн Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, албадан татан буулгасан.
7	Төв ази банк	1992 он	1996 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №194	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Төв ази банк нь хувийн хэвшлийг дэмжих зорилгоор байгуулагдсан анхны банк юм. Барьцаа баталгаагүйгээр их хэмжээний зээл олгосноор санхүү, төлбөрийн чадваргүй болсон. Монголбанкнаас Бүрэн эрхт төлөөлөгч томилж шат дараатай арга хэмжээ авсан. Гэвч өгсөн үүрэг, даалгаврын биелэлт хангалтгүйгээс төлбөрийн чадвар сайжраагүй, хэвийн үйл ажиллагаа хангагдаагүйгээс 1996 оны 05-р сарын 31-ний байдлаар 847.0 сая төгрөгийн алдагдал орж, төсвийн орлого болон харилцагчдын 303.4 сая төгрөгийн төлбөр тооцоог саатуулж, харилцагчдын 772.3 сая төгрөгийн үндсэн хадгаламж, 380.7 сая төгрөгийн хүү, Монголбанкны дахин санхүүжилтийн 569.0 сая төгрөгийн зээлийн төлбөрийг хугацаанд нь хийж чадахгүй саатуулсан тул төлбөрийн чадваргүй болсон гэж үзэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, үйл ажиллагааг зогсоосон.
8	Баянбогд банк		1999 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №426	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Хууль дагаж мэрдэх журмын тухай 1998 оны 08-р сарын 20-ны өдрийн Монгол улсын хууль, Банкны тухай хуулийн 31.9 дэх заалт, Монголбанкны Бодлогын зөвлөлийн 32 тоот хурлын шийдвэрийг тус тус үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.
9	Сэлэнгэ банк	1993 он	1994 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн № 261	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Сэлэнгэ банкны хүсэлт, ХОТШ банкны санал, Монголбанкны Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Банкны тухай хуулийн хүрээнд банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тус банкнийг ХОТШ 1994 оны 10-р сарын 01-ний өдрөөр нэгтгэсэн байна.
10	Монгол бизнес банк		1998 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №418	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Банкнаас олгосон зээлийн чанар муудаж, 2.6 тэрбум төгрөгийн алдагдал үүсч, улмаар төлбөрийн чадваргүй болсон тул Банкны тухай хуулийн 31.8, 24.1.1 заалтын үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.
11	Эдийн тэнгэр банк		1998 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №412	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Банкны тухай хуулийн 31.8, 24.1.1 заалтын үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

12	Экспорт импорт банк	1995 он	1999 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №650	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Банкны үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар өөрийн хөрөнгийн хүрэлцээний дутагдалд орсон, нийт зээлийн үлдэгдэл 100.0 хувь чанаргүй ангилалд орсон нь тус тус тогтоогдсон харилцагчдын төлбөр тооцоог саатуулсан тул Банкны тухай хуулийн 31.9, 38.2, 24.1 дэх заалтын үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.
13	Хадгаламж банк	1996 он	2013 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №А-157	Банкийг албадан татан буулгасан.	Банкны 2013 оны 07-р сарын 21 өдрийн тайлан тэнцлээр банкны нийт актив хөрөнгийн 18 хувь нь чанаргүй болсон, 181.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, бусдад өгөх өглөг нь активаасаа 94.2 тэрбум төгрөгөөр хэтэрч өөрийн хөрөнгө алдагдсан тул Төв банк тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 28 дахь зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.2 дахь заалт 57.3 дахь заалтыг үндэслэн банкнийг албадан татан буулгасан.
14	ММ Инвест банк		1999 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №186	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй тул Банкны тухай хуулийн 31.8 дахь заалт, Монголбанкны бодлогын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.
15	Сэргээн босголтын банк		1999 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №647	Банкийг албадан татан буулгасан.	Сэргээн босголтын банк нь банкны салбарт хийсэн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд байгуулагдсан Төрийн өмчийн банк. Банк нь санхүү, төлбөрийн чадваргүй болсон, мөн банканд бүтцийн өөрчлөлт хийх боломжгүй гэж үзсэн, мөн Эрх хүлээн авагчийн санал, Банкны тухай хуулийн 31, 38 дугаар зүйлийг үндэслэн Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, албадан татан буулгасан.
16	Азийн хөрөнгө оруулалтын банк	1997 он	1999 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №428	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Хууль дагаж мөрдөх журмын тухай 1998 оны 08-р сарын 20-ны өдрийн Монгол улсын хууль, Банкны тухай хуулийн 31-р зүйлийн 9 дэх заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 08-р сарын 09-ний өдрийн 972 тоот тушаалын 3 дахь заалтыг тус тус үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.
17	Улаанбаатар банк	1998 он	1999 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №427	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Хууль дагаж мөрдөх журмын тухай 1998 оны 08-р сарын 20-ны өдрийн Монгол улсын хууль, Банкны тухай хуулийн 31-р зүйлийн 9 дэх заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 08-р сарын 09-ний өдрийн 972 тоот тушаалын 3 дахь заалтыг тус тус үндэслэн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.
18	Зоос банк		2009 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №659	Банкийг албадан татан буулгасан.	Банканд томилогдсон Эрх хүлээн авах ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн хийгдсэн тохируулгын гүйлгээгээр гаргасан тайлан тэнцлээр нийт зээлийн багцын 63 хувь нь чанаргүй болсон, 87.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, бусдад өгөх өглөг нь актив хөрөнгөөс 54.9 тэрбум төгрөг буюу 28 хувиар хэтэрч төлбөрийн чадваргүй болсон тул Төв банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 38, 38.1 дүгээр зүйлийн 3 дахь заалт, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг тус тус үндэслэн банкнийг албадан татан буулгасан.
19	Анод банк	1999	2010 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №446	Банкийг албадан татан буулгасан.	Монголбанкнаас 2008 онд хийсэн шалгалтаар банкны зээлийн ангилал журмын дагуу үнэн зөв хийгдээгүй, өөрийн хөрөнгө нь алдагдсан, ихээхэн хэмжээний алдагдалтай авлагыг нуун дарагдуулсан зэрэг ноштой зөрчил, дутагдал илэрсэн тул Банкны тухай хуулийн 31-р зүйлийн дагуу онцгой дэглэм тогтоож, Бүрэн эрхт төлөөлөгч томилон албадлагын арга хэмжээ авч, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Тус банканд томилогдсон банкны Эрх хүлээн авагчийн зөвлөлийн дүгнэлтээр тайлан тэнцэлд тусгагдсан нийт зээлийн багцын 92.4 хувь нь чанаргүй болсон, 208.9 төгрөгийн алдагдалтай ажиллаж, бусдад өгөх өглөг нь нийт актив хөрөнгөөс 171.8 төгрөгөөр эвдэрч төлбөрийн чадваргүй болсон, тус банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулах замаар нэмэлт хөрөнгө оруулж санхүүгийн байдлыг сайжруулах боломжгүй болсон тул Төв банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь заалт, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг үндэслэн албадан татан буулгасан.
<b>Монголбанкны зөвшөөрөл болон хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр бусад банктай нэгдэж тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон банкны мэдээлэл</b>						
20	Монгол шуудан банк	1993 он	2010 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №252	Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон.	Монгол Шуудан банкны актив, пассив Хадгаламж банканд шилжсэнтэй холбогдуулан Хадгаламж банк ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2009 оны 22 тоот тогтоол, Монгол шуудан банкны нэгдэх ажлын бүрэн эрхт комиссын 2010 оны 13 тоот шийдвэр, Банкны тухай хуулийн 27 дугаар зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.1 тус тус үндэслэн банкны үйл ажиллагаа эрхлэн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.
21	Кредит банк	1997 он	2021 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн А-1/766 дугаар зөвшөөрөл	Тээвэр хөгжлийн банктай нэгдсэн.	Кредит банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 05-р сарын шийдвэр, Тээвэр хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06-р сарын шийдвэр, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 07-р сарын 27-ны өдрийн А-1/766 дугаар зөвшөөрлөөр Кредит банк Тээвэр хөгжлийн банктай нэгдсэн.
22	Улаанбаатар хотын банк	1999 он	2020 он	Монголбанкны Ерөнхийлөгчийн №А-337	Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.	Банкны хувь нийлүүлэгчдийн хурлын 2020 оны 06-р сарын шийдвэр, Банкны тухай хуулийн 27, 28 дугаар зүйл Монголбанкны Ерөнхийлөгчийн А-337 тоот тушаалаар банк байгуулах зөвшөөрлийг тусгай хүчингүй болгосон.
23	Интер банк	2001 он	2006 он	Монголбанкны 6/689 тоот зөвшөөрөл	Капитрон банктай нэгдсэн.	Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Банкны тухай хууль (1996 он)-ийн 30 дугаар зүйл, Интер банкны 2006 оны 02-р сарын хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоол, Капитрон банкны 2006 оны 03-р сарын хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолуудыг үндэслэн тус 2 банк нэгдсэн.